



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Улаанбаатар Эрдэм Их сургууль

Хөтөлбөрийн нэр: Нягтлан бодох бүртгэл

Индекс: D041101

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Далхжав -ХААИС-ийн зөвлөх профессор, доктор

Гишүүд: Х.Нямбаяр -Мандах их сургуулийн НББ-ийн сургуулийн захирал,  
дэд профессор

Б.Оюунсүрэн -ОУУБИС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн  
дэд профессор, доктор

2022 оны 04 сарын 27-ны өдөр

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

- АНУ - Америкийн Нэгдсэн Улс
- БСШУЯ - Боловсрол Соёл шинжлэх ухааны яам
- БШУЯ - Боловсрол Шинжлэх Ухааны Яам
- БМИҮЗ - Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
- БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- БУ - Бизнесийн Удирдлага
- БУТ - Бизнесийн Удирдлагын Тэнхим
- ЭЕШ - Элсэлтийн Ерөнхий Шалгалт
- ЗГ - Засгийн газар
- МУ - Монгол Улсын
- МУИС - Монгол Улсын Их Сургууль
- МНББИ - Мэргэшсэн Нягтлан Бодох Бүртгэлийн Институт
- НББ - Нягтлан бодох бүртгэл
- НББОУС - Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
- НҮТББ - Нийгмийн Үйлчилгээ Төрийн Бус Байгууллага
- ОХУ - Оросын Холбооны Улс
- ОУ - Олон улсын
- ОУУБИС - Олон Улсын Улаанбаатар Их Сургууль
- УБЭИС - Улаанбаатар Эрдэм Их Сургууль
- ХААИС - Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
- ЧДБ - Чанарын Дотоод Баталгаажуулалт
- ЧДБА - Чанарын Дотоод Баталгаажуулалтын Алба
- ШУТС - Шинжлэх Ухаан Технологийн Сан
- ЭЕШ - Элсэлтийн Ерөнхий Шалгалт
- ЭШХ - Эрдэм Шинжилгээний Хурал

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Улаанбаатар Эрдэм Их сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	“Нягтлан бодох бүртгэл” “Accounting”	
<b>Индекс</b>	D041101	
<b>Шинжээчид</b>	Д.Далхжав -ХААИС-ийн зөвлөх профессор, доктор Х.Нямбаяр -Мандах их сургуулийн НББ-ийн сургуулийн захирал, дэд профессор Б.Оюунсүрэн -ОУУБИС-ийн БУТ-ийн дэд профессор, доктор	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Н.Түмэнжаргал	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	4 сарын 15	Шинжээчийн багийг томилох
	4 сарын 16	Өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн багийн гишүүдэд хүлээлгэн өгөх, багийн уулзалт хийх
	4 сарын 21	Урьдчилсан үнэлгээний тайланг сургуульд хүргүүлэх
	4 сарын 26-27	Шинжээчийн баг сургуульдээр очиж ажиллах
	5 сарын 10	Шинжээчийн багийн тайланг сургуульд хүргүүлэх
	5 сарын 15	Сургуулиас саналыг авч, Шинжээчийн багийн тайланг БМИҮЗ-ийн ажлын албанд хүргүүлэх
	5 сар	Мэргэжлийн зөвлөлийн хуралд оруулж хэлэлцүүлэх
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуурын дагуу ажиллав	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Улаанбаатар Эрдэм их Сургууль анх “Эдийн засаг-нягтлан бодогч” мэргэжлээр 1995 онд элсэлт авч, анхны төгсөлтөө 1999 онд хийж, үндэсний хэмжээнд боловсон хүчин бэлтгэж эхэлсэн байна. Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрийн зорилго, зорилтоо дэлхийн болон өөрийн орны хөгжлийн чиг хандлага, сүүлийн үеийн арга зүйтэй уялдуулан авч үзэж “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын сургалтын хөтөлбөрөө гурван удаа шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлж байна.

Сургалтын хөтөлбөрийг “Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын түвшний мэдлэг, чадвар, хандлага, эрх зүй, сургалтын орчин, элсэгчдэд болон багшид тавигдах шаардлага, төгсөгчдийн мэргэших чиглэл /нягтлан бодох бүртгэл/, эзэмших ур чадвар, оюуны үнэлгээний тогтолцоо зэргийг тодорхойлсон цогц баримт бичиг юм” хэмээн тодорхойлсон байна.

Хөтөлбөрийн зорилгоо “Дотоодод төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, оролцогч талуудын шалгуур шаардлагыг хангасан, нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцэн хөгжих чадвартай, зөв хандлагатай чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд оршино” гэж тодорхойлсон.

Улаанбаатар Эрдэм Их Сургууль нь “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын сургалтын хөтөлбөрөөр өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд өдрийн сургалтаар 953, эчнээ оройн сургалтаар 1440, нийт 2393 мэргэжилтэн бэлтгэн гаргажээ. Төгсөгчдийн 80 гаруй хувь нь мэргэжлээр ажиллаж байгаа бөгөөд олон нягтлан бодогчид мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн шалгалтанд тэнцсэн мөн албан тушаалын өсөлт сайн гэсэн судалгааг гаргасан байна.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- УБЭИС нь Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр 1995 оноос эхлэн элсэлт авч 27 дахь жилдээ тасралтгүй сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа, 21 жил төгсөлт хийсэн. Энэ хугацаанд 2393 нягтлан бодогчийг бакалаврын зэрэгтэйгээр бэлтгэсэн.
- Нягтлан бодох бүртгэл сургалтын хөтөлбөрийг энэ хугацаанд 3 удаа шинэчлэн боловсруулсан. Хамгийн сүүлд 2019 онд УБЭИС-ийн ректорын “Хөтөлбөр шинэчлэх тухай” 46 тоот тушаалын дагуу шинэчлэн сайжруулалт хийсэн.
- Хөтөлбөрийн шинэчлэлтийг хийхдээ өөрийн орны хэмжээнд нягтлан бодогчдын ажлын байрны өсөлтөнд судалгаа хийсэн, сүүлийн 5 жилд нягтлан бодогчдын тоо 15 хувиар өссөн болохыг судалгаагаар гаргасан /2015 онд ажлын байр 103,4 мянга байсан бол 2020 онд 119,1 мянга болж өссөн/ тул зах зээлд энэ мэргэжил эрэлт сайн байна гэж үзсэн.
- Нягтлан бодогчдыг өдрийн, эчнээ, оройн гэсэн сургалтын хэлбэрээр бэлтгэдэг.
- Хөтөлбөрт шинэчлэлт хийхдээ төгсөгчид, ажил олгогчид, мэргэжлийн байгууллагууд /оролцогч талууд/-аас санал авсан.

##### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Анхаарах асуудал:

- Тус сургууль нягтлан бодогчийн эрэлт хэрэгцээ зах зээлд байна гэдгийг гаргах оролдлого хийхдээ өөрийн сургууль хэдийг бэлтгэх боломж байгааг нарийн тодорхойлоогүй сул тал ажиглагдав.
- Монгол улсад Нягтлан бодох бүртгэлээр хэдэн их дээд сургууль, коллеж жилд хэдэн хүнийг бакалаврын зэрэгтэйгээр бэлтгэн гаргаж байгааг ажлын байрны өсөлттэй харьцуулан судлаад, өөрийн бэлтгэх нягтлан бодогчийн элсэлтэд зохицуулалт хийдэг байх.

##### Зөвлөмж:

- Хөтөлбөрийг боловсруулахдаа нягтлан бодогчдын ажлын байрны өсөлтөд судалгаа хийсэн боловч манайд хэдэн сургууль, хэдэн хүнийг энэ мэргэжлээр бэлтгэн гаргаж

байгааг судалсан эсэх нь тодорхой бус байна. Иймд эрэлт нийлүүлэлтийн зөрүүг харгалзан үзэж, өөрийн хөтөлбөрөөр авах элсэлтийн тоог тогтоодог байх.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Нягтлан бодох бүртгэл бакалаврын сургалтын хөтөлбөрийн зорилгоо “Дотоодод төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, оролцогч талуудын шалгуур шаардлагыг хангасан, нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцэн хөгжих чадвартай, зөв хандлагатай чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд оршино” гэж тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхийн тулд дараах 4 зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:
  1. Нягтлан бодогч мэргэжлээр төгсөгчид нь ажлын байран дээрээ мэргэжлийн болон ёс зүйн хувьд үлгэрлэж чаддаг болсон байна.
  2. Төгсөгчид нь бүх шатны аж ахуйн нэгж байгууллагад нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дадлагажсан байна.
  3. Төгсөгчид нь судалгаа шинжилгээ хийх ахисан түвшний боловсрол эзэмшихийг хүсэж зорьдог болсон байна.
  4. Төгсөгчид нь багаар ажиллах бие даан удирдан зохион байгуулах ажилд оролцдог болсон байна.
- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн зорилго, зорилт, төгсөгчийн хүрсэн байх түвшинг /PEO/ тодорхойлсон
- Хөтөлбөрийн зорилго зорилт болон хөтөлбөрөөр суралцахуйн үр дүнгийн уялдааг /PLO/ гаргаж харуулсан
- “Нягтлан бодох бүртгэл” сургалтын хөтөлбөрийн зорилгоо өөрийн орны томоохон нэр бүхий 7-9 их сургуулиудын нягтлан бодох бүртгэл бакалаврын сургалтын хөтөлбөрийн зорилго зорилттой харьцуулан жишиж үзсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн зорилгод ... Дотоодод төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, оролцогч талуудын шаардлагад нийцсэн байх гэж тодорхойлсон боловч өнгөрсөн 27 жилийн хугацаанд сургалтын хөтөлбөрөө дотооддоо магадлан итгэмжлүүлээгүй явж ирсэн.

#### **Зөвлөмж:**

- Улаанбаатар Эрдэм Их сургуулийн “НББ-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр”-ийн онцлог, гарцаагүй байх үндэслэлийг хөтөлбөрийн шинэчлэлд оруулж өгөх.

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын төлөвлөгөөг боловсруулахдаа гадаадын болон дотоодын их сургуулиудын НББ-ийн сургалтын хөтөлбөртэй харьцуулалт хийсэн. Харьцуулалтыг ерөнхий эрдмийн болон мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүд мөн түүнчлэн сонгон болон заавал судлах гэх мэтээр гаргаж харьцуулсан. /Хүснэгт 1.6-1.7 ба 1.8/
- НББ-ийн сургалтын хөтөлбөрийг 2014-2015, 2018-2019, 2020-2021 оны хичээлийн жилд нийтдээ 3 удаа шинэчлэн сайжруулалт хийсэн /ректоров 2018 оны 36, 2019 оны 01, 2021 оны 57 тоот тушаалуудаар шинэчлэн баталсан/.
- УБЭИС –ийн хөтөлбөрийн хороогоор 2021 оны 09 сарын 8-ны өдөр хэлэлцүүлж баталсан төлөвлөгөөг оюутны зөвлөх хөтөлбөр болгон оруулсан байна. Энэхүү хөтөлбөрөөс үзвэл хичээлийн жилийн нэг үе буюу хагас жилд оюутан дунджаар 14-20 багц цагийн хичээл судлахаар төлөвлөсөн байна. Оюутны ачааллын хувьд боломжит түвшинд гэж үзлээ.
- Хөтөлбөр боловсруулах шинэчлэлт хийхдээ оролцогч болон сонирхогч талуудаас нэг удаа санал авсан судалгааны материал хүн нэг бүрээр байгаа ч нэгтгэн дүгнэж хэлэлцсэн хурлын материал, хөтөлбөрт оруулахаар шийдсэн албан ёсны шийдвэр байгаа эсэх нь тодорхой бус байна.
- Хөтөлбөрийн хичээл тус бүрээр олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадвар, төлөвшүүлэх хандлагын талаар зураглал гаргаж матриц хэлбэрт оруулсан. /Хүснэгт 2.4/
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг харуулсан /Хүснэгт 2.4/ зураглалыг оюутнууд ойлгохгүй байгаа нь тэдэнтэй хийсэн уулзалтын явцад ажиглагдсан.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутнуудад зориулж суралцах хугацаандаа судлах хичээлүүдээ зөв тэнцвэртэй хуваарилан сонголт хийх боломж олгох зорилгоор зөвлөх хөтөлбөр боловсруулсан /хүснэгт 1.10/.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр боловсруулахдаа ямар хичээлээр ямар мэдлэг олгох, ямар ур чадвар эзэмшүүлэх, оюутанд ямар хандлага төлөвшүүлсэн байхыг ойлгомжтой хэлбэрээр дүрслэн харуулах. Өөрөөр хэлбэл /хүснэгт 2.4/-ийг энгийн ойлгомжтой байдлаар дүрслэх. Оюутнуудтай хийсэн уулзалтаар энэ асуудал хөндөгдөж байсан.

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**



## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### 2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### Илрэл нотолгоо:

- БСШУС-ын сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-д сургалтын хөтөлбөр 12 бүрдэл хэсэгтэй байхаар заасныг мөрдлөг болгосон.
- Нягтлан бодох бүртгэл сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа Сэтгэх-зохион-бүтээх-хэрэглэх, Бүтээлчээр холбох арга, Шинжлэх-зохиох-хөгжүүлэх-хэрэглэх-үнэлэх гэсэн аргаас 3 дахь арга болох “Шинжлэх-Зохиох-Хөгжүүлэх-Хэрэглэх-Үнэлэх” (ADDIE-Analyze, Design, Development, Implementation, Evaluation) аргыг сонгон авч ашигласан гэж тайлагнажээ.
- Хөтөлбөрөөр нийтдээ 128 багц цагийн хичээл судлах төлөвлөгөөтэй, үүнээс заавал судлах нь 102 багц цаг буюу нийт судлах хичээлийн 80% нь заавал судлах хичээл байна.
- Сургалтын төлөвлөгөөнд багтсан хичээлүүдийн нийт багтаамж 128 багц цаг, үүнээс ерөнхий эрдмийн хичээл 38 багц цаг, мэргэжлийн суурь хичээл 31 багц цаг байгаа бол мэргэшүүлэх хичээл 59 орчим багц цаг байна. Сургалтын багц цагийн эзлэх хувийн жинг дотоодын 9 их сургуулийн ижил хөтөлбөртэй харьцуулан жишиж үзсэн.
- Мэргэшүүлэх хичээлийн багц цагаас 7 багц цаг нь дадлага болон төгсөлтийн ажлаар цуглуулах боломжтой байна.
- Оюутны сонгон судлах хичээлийн боломж бусад хөтөлбөрүүдээс 7 орчим багцаар бага, заавал судлах хичээлийн багц 8 орчим багц цагаар их байгаа нь ажиглагдав.
- Сургалтыг кейс сургалт, цогц бодлого бодуулах, харилцан ярилцах, хэрэглээний жижиг цахим программ дээр ажиллуулах гэх мэт аргууд ашиглан явуулдаг байна.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Анхаарах асуудал:

- Оюутны хичээл сонгох боломжийн хувьд мэргэшүүлэх хичээлийн 8,5 хувь буюу 5 багц цагийн хичээлийг сонголтоор үзэх боломжтой байхаар төлөвлөсөн. Гэхдээ хичээл сонголтыг оюутнууд хийдэггүй, сургалтын албанаас шууд хийдэг болохыг оюутнууд илтгэж байв. Хичээл сонголт үнэн хэрэгтээ алга байна.

#### Зөвлөмж:

- Мэргэшүүлэх хичээлийн багцад сонгон судлах хичээлийн тоог нэмэгдүүлэх, оюутан чөлөөт сонголтоор сонирхсон хичээлүүдээ судлах боломж бүрдүүлэх.

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрт багтсан хичээлүүдийг заах арга нь CDIO арга байсан бөгөөд одоо хөтөлбөрийн сургалт бүхэлдээ “С” загварт шилжиж байгаа. “С” загвар буюу “Бүтээлчээр холбох арга” гэдэг нь хичээл бүрийн өмнөх ба дараах холбоо, тэрчлэн тухай хичээлийн сэдэв ба мэргэжлийн хөтөлбөрийн уялдаа, сургалтын арга зүйг цогц байдлаар тусгасан загвар юм.
- Суралцагсдад олгох мэдлэг, эзэмшүүлэх ур чадвар, төлөвшүүлэх хандлага зэргийг цогц байдлаар хүргэхэд чиглэгдсэн шавь төвтэй сургалтыг явуулдаг. Тухайн хичээлээр ямар мэдлэг олгох гэж байгаагаас хамаарч сургалтын олон аргуудаас багш сонголт хийж хичээлийг заадаг.
- Нягтлан бодох бүртгэлийн мэргэшүүлэх хичээлүүдийн тухайд сургалтын болон үйлдвэрлэлийн дадлагын хичээлийг МНББИ-ийн сургалтын баазыг түшиглэн явуулж ирсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сүүлийн 2 жилийн онцлог байдалтай холбогдуулан цахим сургалт, явуулж ирсэн багш нар бүх хичээлийг “Е” хэлбэрт оруулсан, сургууль дотор бичлэгийн студи байгуулсан, цахим хичээлийг явуулах боломжийг бүрдүүлж чадсан.
- Сургалтын чанарыг сайжруулахын тулд хоцрогдол арилгах зорилгоор шаардлагатай оюутнуудад давтлага өгдөг.

### **Анхаарах асуудал:**

- Сүүлийн 2 жилд “Ковид 19” цар тахлын улмаас МНББИ-ийн сургалтын баазыг түшиглэн явуулах үйл ажиллагаа тасалдсан. Цаашид Нягтлан бодох бүртгэлийн дадлагын хичээлийг мэргэжлийн программ дээр заах, дадлагажуулах боломж хязгаарлагдсан.
- Сургууль удирдлагын мэдээллийн системээ шинэчилж байгаа ч хэт удаашралтай, оюутан вэбгүй учир хичээл сонголт, дүнгийн мэдээлэл, төлбөр тооцоогоо шууд харах боломжгүй байна.

### **Шаардлага:**

- Удирдлагын мэдээллийн системийн шинэчлэлээ яаралтай дуусгаж, оюутны вэб-ийг ажиллагаатай болгох.
- Сургалтын /танилцах/ болон үйлдвэрлэлийн /мэргэшүүлэх/ дадлага хийх орчноо бүрдүүлэхэд анхаарч, ажил олгогчидтой гэрээ байгуулж хамран ажиллах.

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дээд боловсролын зэрэг олгох сургалтад багц цагийг хэрэглэх, дүйцүүлэх суралцагсдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд баримтлах үлгэрчилсэн журмыг баримтладаг.
- Оюутны мэдлэгийг үнэлэх журамтай. 100 онооны системтэй. Багш хичээл заах явцад 70 хүртэл оноо өгнө. Явцад 40-өөс дээш оноо авсан оюутныг улирлын шалгалтад оруулна. /Хүснэгт 2.11/
- Оюутны мэдлэг чадварыг үнэлэхдээ сургалтын кредит тогтолцооны зарчимд нийцүүлэн үнэлж дүгнэдэг байна. /Хүснэгт 2.8/; /Хүснэгт 2.9/; /Хүснэгт 2.10/
- Улирлын эцэст шалгалт авсан хичээл тус бүрээр дүнгийн шинжилгээ хийж, тэнхмийн хурлаар хэлэлцүүлдэг.
- Оюутны судалсан хичээлийн багц цаг 60 хүрсэн боловч үнэлгээний голч 1.8-аас доош бол цааш хичээл үргэлжлүүлэн үзэхийг зогсооно. Энэ хугацаанд хангалтгүй шалгагдсан хичээлүүдээ дахин судлах боломж олгоно.
- Тус сургууль оюутныг үнэлэх үнэлгээний арга аргачлал сайтай болох нь эндээс ажиглагдсан болно.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны судалсан хичээлийн багц цаг 60 хүрсэн боловч үнэлгээний голч 1.8-аас доош бол цааш үргэлжлүүлэн хичээл үзэхийг зогсооно. Энэ хугацаанд хангалтгүй шалгагдсан хичээлүүдээ дахин судлах боломж олгоно.

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургалтын үйл ажиллагаа явуулах нийт талбай 7323 м<sup>2</sup>, үүнээс Нягтлан бодох бүртгэл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хичээлийн “А” байрны нийт талбай 1458 м<sup>2</sup>. Нэг оюутанд ногдох талбай 10,1 м<sup>2</sup> /хүснэгт3.2/ одоо НББ хөтөлбөрөөр 54 оюутан суралцаж байна.
- Лекцийн болон семинарын хичээлийн танхимууд самбар, проектор ширээ сандал байх ёстой тавилга хэрэгсэл бүрэн тоноглогдсон /хүснэгт 3.6/, /хүснэгт 3.7/
- Оюутны дотуур байр хичээлийн байртай үргэлж нэг дор байдаг. Нэг оюутанд ногдох оюутны дотуур байрын талбай 13,75 м<sup>2</sup>.
- Нягтлан бодох бүртгэлийн дадлагын хичээл явуулах компьютерээр тоноглогдсон танхимуудтай, 1 оюутанд ногдох талбай 5,5 м<sup>2</sup> байгаа нь стандартаас 2 дахин илүү.
- Номын сан уншлагын заал ширээ сандал хангалттай /хүснэгт3.3/
- Анги танхим хүрэлцээтэй, энэ нь элсэгчдийн тоо цөөрсөнтэй холбоотой ч байж болох.
- Тоног төхөөрөмж боломжит хэмжээнд хангагдсан.
- Багшийн ажлын өрөө ширээ сандал зай талбай хүрэлцээтэй, багш нарт зөөврийн компьютер авч өгсөн, ажиллах орчин сайн.

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Анхаарах асуудал:

- Хичээлийн бус цагаар оюутнууд сууж хичээл давтах анги танхим, номын сангийн уншлагын заал зэргийг орой эрт хаадаг тул оюутнуудад бэрхшээлтэй, мөн сургуулийн орчинд интернет хязгаарлагдмал хүрээнд байдаг сул талтай.

#### Зөвлөмж:

- Сургуулийн орчинд оюутнуудад интернет үйлчилгээг чөлөөтэй болгох.
- Суралцагсдын саналыг авч Номын сан, Уншлагын танхимын ажиллах цагийн хуваарийг нэмэгдүүлэх

#### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр суралцагсдад зориулж компьютерийн MS OFFICE, MS ACCESS, MS EXCEL, SPSS, E-VIEWS, ARTLAB зэрэг хэрэглээний жижиг программуудыг сургалтад ашигладаг /Хүснэгт 3.10/
- Нягтлан бодох бүртгэлийн хичээлийн сургалтанд “Е” контентийн сургалтын хэрэглэгдэхүүн сайн хийгдэж байгаа, энэ нь сүүлийн 2 жилийн нөхцөл байдлаас шалтгаалсан байх талтай.
- Цахим сургалтад MS Teams, Zoom meeting зэргийг ашиглан багш оюутны эргэх холбоог чөлөөтэй явуулж ирсэн, улирлын эцсийн шалгалтыг Google form, Google meeting, Zoom, Teams ашиглан аман болон бичгийн хэлбэрээр авсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Интерактивын орчинд Нягтлан бодох бүртгэл хөтөлөлт, санхүүгийн тайлан гаргах хэрэглээний программ байхгүй нь учир дутагдалтай байна. Орчин үед нягтлан бодох бүртгэлийг гараар хөтөлдөг нягтлан бодогч байхгүй, бүгд интерактивын орчинд цахим программ ашиглаж байна.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын болон мэргэшүүлэх дадлагын хичээлийн хүрээнд оюутнуудад мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэхэд зориулагдсан нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан гаргах **хэрэглээний программ** байхгүй нь онол практикийн цогц чадамж олгоход учир дутагдалтай байна.

#### **Шаардлага:**

- Нягтлан бодох бүртгэлийн хэрэглээний программ авч сургалтанд ашиглах

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Тус сургуулийн номын сан 32,0 мянга гаруй ном, кассет, CD, DVD бичлэг бүхий судалгааны бүтээлүүдтэй. 4 суурин компьютерт суулгасан 500 гаруй электрон номтой, үүнээс 200 гаруй ном нь нягтлан бодох бүртгэлийн сургалтад холбогдолтой.
- Багш оюутнууд ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлүүдийг цахимаар хайх боломж бүрдүүлсэн.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Цахим номын тоог нэмэгдүүлэхэд анхаарч байгаа сайн тал ажиглагдсан.

#### **Анхаарах асуудал:**

- Номын фондын баяжилтыг жил бүр тэнхмүүдээс захиалга авч хийдэг. 2015-2021 онуудад Нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 20,2 сая төгрөгөөр 873 ширхэг ном авсан гэсэн мэдээллийг тайланд оруулсан байв /Хүснэгт 3.11, Хүснэгт 3.12/. Энэхүү мэдээллийг сургуулийн орчинд очиж бодит байдалтай танилцахад Нягтлан бодох бүртгэлийн сүүлийн үеийн стандартуудын чиглэлээр баяжилт хийгдээгүй, дунд шатны бүртгэлийн ном сурах бичгүүд 10 жилийн өмнө /2011 оноос урагш/ гарсан байгаа нь ном сурах бичгийн баяжуулалт шинэчлэл сайн биш байгааг харуулж байна.
- Номын сангийн үйлчилгээний талаар оюутнууд номын сан эрт хаадаг тул даалгавар хийхэд хүндрэл үүсдэг тухай ярьж байв.

#### **Зөвлөмж:**

- Номын санд нягтлан бодох бүртгэлийн сүүлийн үеийн ном сурах бичгүүдээр баяжуулалт хийх.
- Өөрийн орны болон гадны улс орнуудын их сургуулиудын номын сантай хамтын ажиллагаа өргөжүүлж, сүүлийн үеийн ном сурах бичиг эрдэм шинжилгээний бүтээлүүдийг татан авч сургалтанд ашиглах.

### **3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

##### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

Хөтөлбөрийг боловсруулахад оролцогч талууд болон сонирхогч талуудын оролцоог ханган ажилладаг нь дараах зүйлсээс харагдаж байна.

- УБЭИС-ийн ректорын (2019.01.23) Хөтөлбөрийг хороо шинэчлэн байгуулах тухай №01 тоот тушаал

- УБЭИС-ийн ректорын тушаал (2019.01.23 №01) Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны журам
- УБЭИС-ийн ректорын тушаал (2019.06.27) Хөтөлбөрүүдийг шинэчлэх ажлын тухай
- УБЭИС-ийн ректорын тушаал (2019.10.15 №57) Хөтөлбөрийг хороо шинэчлэн байгуулах тухай
- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрийн оюутнуудтай хийсэн уулзалтын тэмдэглэл
- Ажил олгогч нартай хийсэн уулзалтын тэмдэглэл
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа зэрэг баримт бичгүүдийг бүрдүүлжээ.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2019 оны тушаалаар хөтөлбөрийн хороо 7 гишүүний бүрэлдэхүүнтэй, өргөтгөх гишүүдийг оролцуулж (сургууль бүрийн төлөөлөл орно) өргөтгөсөн хурлыг зохион байгуулдаг, мөн ажил олгогч, төгсөгчийн төлөөлөл ордог.
- Хөтөлбөрийн удирдлагын мэдээллийн системийн UNICON програм ашигладаг байсан, 2022 оноос ULMS системийг нэвтрүүлж эхэлсэн.
- Хөтөлбөрийн тасралтгүй шинэчлэл хийдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын албанаас хөтөлбөрийн хороог шинэчлэх талаар оролцогч талуудын саналыг авсан гэх боловч нотлох баримтгүй байна. Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад нийгмийн болон бусад оролцогч талуудын оролцоо бага байна.
- ULMS удирдлагын мэдээллийн системийн нэвтрүүлэлтийн ажил удаашралтай, оюутнууд сургалтын явц болон хөтөлбөрийн мэдээллийг шууд хүлээн авах боломж хомс байна.
- Оролцогч талуудаас авсан судалгааны үр дүн, жилийн болон улирлын тайланд дүн шинжилгээ хийж, ахиц дэвшлийг тухай бүрт дүгнэдэггүй болох нь ажиглагдсан.

#### **Зөвлөмж:**

- Оролцогч талуудын санал, хүсэлтийг хүлээн авах, сонсох тогтолцоог төлөвшүүлэх зэрэг ажлуудаа нотолгоожуулах

#### **Шаардлага:**

- ULMS системийг яаралтай нэвтрүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад нийгмийн болон бусад оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх

## **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож ажилладаг нь дараах зүйлсээс харагдаж байна. Үүнд:
  - Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгүүд
  - Хамтарсан бүтээлүүд
- Улаанбаатар эрдэм их сургуулийн төгсөгчдийн холбоо НҮТББ-ийн 8040567 тоот регистрийн дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ, Төгсөгчдийн холбооны дүрэм, Төгсөгчдийн холбооны хурлын тэмдэглэл, Төгсөгчдийн холбооны гишүүдийн мэдээлэл, Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд зэрэг нь төгсөгчдийн холбоо төгсөгчдөд зориулж тодорхой арга хэмжээнүүд зохион байгуулж, эргэх холбоотой ажилладаг гэдгийг харуулж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- УБЭИС-ийн төгсөгчдийн дунд уулзалт семинар зохион байгуулах, эрдэмтэн, доктор, профессоруудыг алдаршуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр төгсөгчдийн холбоо НҮТББ байгуулж, улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.
- Япон, БНХАУ, ОХУ, АНУ-ын 10 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг. /Хүснэгт 4.2/

#### **Анхаарах асуудал:**

- НББ-ийн хөтөлбөрийн чиглэлээр дотоод болон гадаад хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ хангалтгүй. Хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг ч НББ-ийн хэрэгжүүлсэн төсөл харагдахгүй байна.
- Төгсөгчдийн холбоотой, улсын бүртгэлийн гэрчилгээтэй гэхдээ үйл ажиллагаа нь жигдрээгүй, цар тахлаар зогсонги байдал орсон гэх тайлбар өгч байв. Цаашид цахимжуулах боломж бий гэдгийг анхаарч, цахим орчинд ажиллах нь цаг хэмнэх боломжтой байж болох талтай. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа төгсөгчдөд хүрдэггүй, мэдээ мэдээллийг ямар сувгаар хэрхэн хүрдэг нь тодорхой бус байна.

#### **Зөвлөмж:**

- НББ-ийн хөтөлбөрийн хамтын ажиллагаа, тэтгэлэг, хамтарсан хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх.



- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг жигдрүүлэх, цахим хуудастай болгох, харилцаа, хамтын ажиллагаа, эргэх холбоог сайжруулах, төгсөлтийн дараах давтан сургалт зохион байгуулах.
- Эрдэм шинжилгээ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр дотоодын болон гадны улс орнуудын сургалтын болон судалгааны байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх.

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн үндсэн орлого сургалтын төлбөрөөс бүрддэг. Сүүлийн жилүүдэд элсэлт цөөрч үүнийг дагалдан орлого буурсан энэ хэмжээгээр үйл ажиллагаа алдагдалд орж эхэлсэн. /Хүснэгт 4.4/ Элсэлтийн тоог тогтвортой барих зорилгоор сургалтын төлбөрөө нэмээгүй, мөн сургуулийн барилга байгууламж, тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийсэн зэрэг шалтгаан нь үйл ажиллагааны алдагдал нөлөөлөл үзүүлсэн. Гэвч ШУТС-ийн төсөл хэрэгжүүлж олсон орлого, хандив тусламж цуглуулах зэрэг ажлын үр дүнгээр алдагдлаа нөхсөн. Зарим хэсгийг багш, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд зарцуулсан гэсэн мэдээллийг тайланд тусгасан.
- УБЭИС-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь их сургуулийн удирдах зөвлөлөөр баталсан тухайн жилийн төсвийн хүрээнд хэрэгждэг. Санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг тухай тайланд дурьдсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Сургуулийн орлогын хэмжээ буурсан.
- НББ-ийн хөтөлбөрийн хувьд зөвхөн сургалтын төлбөрөөс гол орлогоо олдог.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулдаг хувь хэмжээ, үр дүн тодорхой бус.
- Одоогоор НББ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багшийн хөгжилд, оюутны эрдэм шинжилгээний ажилд зориулан гаргах мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэл харагдахгүй байна.
- Төсөл хөтөлбөрөөр мөнгө орж ирдэг гэхдээ нягтлан бодох бүртгэлээр хэрэгжүүлсэн төсөл байхгүй, элсэлт буурсан, хөтөлбөр алдагдалтай, нэг оюутанд ногдох өртөг зардал тооцоогүй байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.
- Нэг оюутанд ногдох өртөг зардлыг тооцох.

### **Шаардлага:**

- НББ хөтөлбөр хэрэгжүүлэгч байгшийн хөгжилд, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд зориулсан төсвийг жил бүр батлан өгч гүйцэтгэлийг хангаж ажиллах.
- Хөтөлбөр сургуульд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэх, өртөг зардлын тооцооллыг хийж үнэлэн дүгнэж байх.
- Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс санхүүжих боломжийг жил жилээр тодорхойлон төлөвлөж, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн оролцоог хангаж ажиллах.

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Үйл ажиллагааны үр дүн, багш нарын эрдэм судлал, бүтээлийг нийтийн хүртээл болгох маркетинг идэвхжүүлэлтийн бодлого баримталах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна. Үүнд:
  - УБЭИС-ийн элсэлт, маркетингийн төлөвлөгөөтэй
  - Мэргэжил сурталчлах өдөрлөг жил бүрийн намар зохион байгуулдаг
  - Хүмүүнлэг, нийгэмд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан тайлан, мэдээтэй
- Хөтөлбөр тогтвортой байдлаа хангах ажил хийж байгаа ч элсэгчийн тоо буурч байгаа нь дээрх ажлууд бодит үр дүнгээ өгөхгүй байгааг илтгэж байна. Хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахад нөлөөлж болох дараах зүйлсийг хийж хэрэгжүүлээгүй байна. Үүнд:
  - Хөтөлбөр хэрэгжүүлдэг нэгжийн Фэйсбүүк байхгүй
  - Сургуулийн вэб-ээс НББ хөтөлбөртэй холбоотой мэдээлэл харагдахгүй байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Үйл ажиллагааны үр дүн, багш нарын эрдэм судлал, бүтээлийг нийтийн хүртээл болгох маркетинг идэвхжүүлэлтийн бодлого баримталдаг.
- Мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулдаг.
- Хүмүүнлэг, нийгэмд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулдаг.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн оюутны тоо буурсан, их сургуулийн босго оноо өссөн зэрэг нь маркетинг идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг харуулж байна.
- Сургуулийн болон хөтөлбөрийн вэб –ийн ашиглалтаа сайжруулах.

### **Зөвлөмж:**

- Маркетинг идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, элсэлтийн тоонд анхаарах, цар тахал гэх мэт нийгмийг хамарсан хямралын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь вебсайт болон социал сувгуудаар өөрийн үйл ажиллагааны талаар <http://ubeu.edu.mn/> ; <https://www.facebook.com/ube.university> мэдээллийн суваг ашиглан хүргэдэг байна.
- Мөн нягтлан бодох бүртгэл мэргэжил сурталчлах өдрүүд 7 хонгийн арга хэмжээ зохиож, оролцогч талуудыг татан оролцуулдаг.
- Санхүүгийн байгууллага үүсч хөгжсөний ойн арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг.
- Монголын радио, Соён гэгээрүүлэх телевиз, Зуун мэдээ сонин зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сургуулийн үйл ажиллагааг сурталчилсан цуврал лекц, ярилцлага сурталчилгааг явуулдаг. /Хүснэгт 4.6/

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Элсэлт болон сургуулийн мэдээллийг тогтмол мэйлээр, гар утсаар, мэдээллийн ажилтнаар дамжуулан түгээдэг.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагаанд зориулан сурах бичиг, гарын авлага, боловсруулан олны хүртээл болгодог. 2016-2021 онд 24 сурах бичиг, гарын авлага олны хүртээл болгосон байна.

##### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой мэдээлэл тогтмол хүрдэггүй.

##### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн цахим хуудас ашиглах, вебсайтын мэдээллийн иж бүрэн байдалд анхаарах

##### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Элсэлтийн ажил зохион байгуулах ректорын тушаал жил бүр гардаг. 2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн ажлыг зохион байгуулах Ректорын тушаал 2021.07.07 өдөр гарсан байна. Уг тушаалд үндэслэн оюутан элсүүлэх журмаар шинэ элсэгчдийг сонгох, элсүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж оноо сүүлийн 4 жилд 445 байна.
- Шинэ суралцагчдад зориулсан чиглүүлэх сургалтыг сургууль, тэнхимээс зохион байгуулдаг. Сургууль, тэнхимийн жил бүрийн чиглүүлэх сургалтын хөтөлбөрт үндэслэв.
- Гадны улс орнуудаас 80 гаруй оюутан элсэн суралцаж байгаа боловч нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн хувьд байхгүй байна.
- Элсэгчдэд зориулсан тараах материал
- Элсэлтийн комиссын тушаал

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Шинээр элссэн оюутанд чиглэсэн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, төлбөр төлөлтийн уян хатан нөхцөл бий болгодог нь суралцагчдын сэтгэл ханамж өндөр байдаг. ЭЕШ онооноос хамаарч сургалтын төлбөрийг 50 хүртэл хувийн хөнгөлөлт үзүүлдэг. Мөн шинээр элсэгчид төлбөрөө 8 сардаа багтаан төлбөл тодорхой хөнгөлөлтийг үзүүлдэг.
- Хичээлийн жилийн эхэнд шинээр элссэн суралцагчдад чиглүүлэх сургалтыг сургууль, тэнхимээс хөтөлбөр гарган хийдэг.
- Элсэлттэй холбоотой мэдээллийг цахим сүлжээний сувгуудыг ашигладаг. Сургуулийн <http://ubeu.edu.mn/> хуудсаар дамжуулан элсэлт цэсээр орж элсэлтийн бүртгэл, мэдээлэл, журмыг харах боломжийг шинээр элсэгчдэд зориулан бий болгосон.

#### Анхаарах асуудал:

- Оюутны гарын авлагатай болох, оюутантай холбоотой дүрэм журмыг нээлттэй болгох.
- НББ мэргэжлээр нийт 54 оюутан суралцаж байна. Цаашид тухайн хөтөлбөрөөр элсэгчдийн тоог нэмэгдүүлэхэд элсэлтийн бодлого, маркетингийн үйл ажиллагаанд анхаарч, элсэн суралцах хүсэлтэй суралцагчдад мэдээлэл авах эх сурвалжуудыг нэмэгдүүлэх.
- Элсэлтийн босго оноо их сургуульд 480 болгосныг анхаарч ажиллах.

#### Зөвлөмж:

- НББ хөтөлбөрөөр элсэгчдийн тоог нэмэгдүүлэхэд элсэлтийн бодлого, маркетингийн үйл ажиллагааг чиглүүлэх.
- Сургуулийн албан ёсны цахим хуудсанд оюутантай холбоотой дүрэм журмыг нээлттэй болгож, мэдээллийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх.
- Оюутны вэб-ийг яаралтай ажиллагаатай болгох.

## **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

1. Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан:
  - Оюутанд хууль зүйн зөвлөгөө өгөх зөвлөмж боловсруулахдаа МУ-ын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 228 дугаар тогтоолыг үндэслэсэн.
  - Оюутны хөгжлийн хөтөлбөр 2021.08.24-ны А/27 тоот Ректорын тушаалаар баталсан.
  - Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх журамтай.
  - Сургуулийн эмчтэй. Оюутанд чиглэсэн үзлэг, оношлогоог хийх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудыг хийдэг. /2021 оны 12 сарын 15 ны өдрийн тайлан/
  - Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн дэргэд оюутны илтгэлийн клуб ажилладаг.
2. Оюутнаас сэтгэл ханамжийн судалгааг хичээлийн жилийн хугацаанд улирал бүр үндсэн 2 бүлгээр авдаг. Үүнд:
  - Сургалтын үйл явцын талаар хичээл бүрээр
  - Сургалтын орчин болон үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг авсан байна.
3. Суралцагчдад чиглэсэн эрүүл мэндийн боловсрол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтуудыг сургууль, тэнхимийн зүгээс холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Тухайлбал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэс, Эрүүл мэндийн боловсрол сургалтыг Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулсан.
4. Оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажлыг мэргэжлийн багш нар удирдан чиглүүлдэг. Оюутны эрдэм шинжилгээний хурал жил бүр бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд зохион байгуулагдаж, шалгарсан илтгэл нь сургуулийн нэгдсэн хуралд орно. Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн хувьд Нягтлан бодох бүртгэл мэргэжлээр жилд дунджаар 10 гаруй оюутан оюутны эрдэм шинжилгээний хуралд оролцдог байна. Тэнхимийн багш нар жилд дунджаар 2-оос дээш оюутан удирдаж оруулдаг /Тэнхимийн ажлын тайланд үндэслэв/.
5. НББ-ийн бага олимпиадыг жил бүрийн 12 сард санхүүчдийн баяртай зэрэгцүүлэн мэргэжил сурталчлах өдөрлөгийн хүрээнд зохион байгуулдаг. Тус олимпиадад НББ мэргэжлийн ангийн оюутнуудаас баг гарч, шалгарсан багийг улсын олимпиадад

бэлтгэдэг. Мөн тус өдөрлөгөөр НББ-ийн төгсөгчид ирж мэргэжлийн үнэ цэн, ажлын байранд гараад анхаарах асуудлаар яриа хийн, зөвлөгөө өгдөг.

6. Зөвлөх багш нь оюутанд хичээл сонголт, төлбөр төлөлт, дүнгийн голч гаргаж өгөхөд чиглүүлэн тусалдаг. Багш хичээлээс гадуур оюутанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг. Улирал тутам тэнхимд оюутанд зөвлөх үйлчилгээний хуваарь гардаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны хөгжлийн хөтөлбөрийг баталсан. 2021.08.24
- НББ-ийн бага олимпиадыг мэргэжил сурталчлах өдөрлөгийн хүрээнд зохион байгуулдаг.
- Сургуулийн стратеги төлөвлөгөө 2018-2025 ийн тэргүүлэх чиглэлийн 3-д “Нийгэм, суралцагчдад үзүүлэх үйлчилгээг хөгжүүлэх” хэсэг дээр үндсэн гурван дэд зорилтын хүрээнд суралцагчдад үзүүлэх үйлчилгээний талаар тусгагдсан.
- Зөвлөх багш нь дааж авсан 1-4-р курсын оюутнуудад хичээл сонголт, төлбөр төлөлт, дүнгийн голч гаргаж өгөхөд чиглүүлэн тусалдаг.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаанд багш оюутны суралцаж буй эсэхэд анхаарал тавьдаг байдал 82%, багийн хувийн соёл оюутантай харилцах ёс зүйн үнэлгээнд 85%, хичээлийн агуулгын ойлгомжтой байдал 89% сэтгэл ханамжтай байна.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаанд анги танхимын тохижилт үнэлгээнд 32%, сургуулийн захиргаа, санхүүгийн ажилтны үнэлгээнд 36%, оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд 39% сэтгэл ханамжтай байлаа.

#### **Зөвлөмж:**

- “Оюутны хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд анхаарч хэрхэн үнэлж дүгнэх, сайжруулах арга замыг тодорхойлох.
- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн сургуулийн орчин, анги танхимын тохижилт, захиргаа, удирдах ажилтны зан харьцаа, оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд анхаарч зөвлөн туслах.
- Оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн мэргэжлийн хөтөлбөрийн үнэлгээг жилд тутам хийж, ахиц дэвшлээ үнэлдэг байх.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- НББ хөтөлбөрийн оюутнууд нь 4 төрлийн дугуйланд давхардсан тоогоор 8-15 оюутан хамрагдаж байна. Сургуулийн хэмжээнд 7 төрлийн дугуйлан байна.
- Сургуулийн зүгээс амьжиргааны түвшин доогуур оюутныг санхүү, эрүүл мэндийн үйлчилгээний дэмжлэгийг ректорын тушаалаар үзүүлдэг. Ковидын үед цахим сургалтад орох датаг бэлтгэж өгсөн. Мөн сайн дурын сургалтуудыг хийдэг. Үүнд: Онцгой байдлын сургалт, эрүүл мэндийн үзлэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цус хандивлах, спорт дугуйлан г.м.
- 2017 онд НББ-ийн улсын олимпиадад 5 оюутанд оролцоод Ректорын 94 тоот тушаалаар 3 кредитийн хөнгөлөлт үзүүлсэн. 2018 оны 102, 2019 оны 115 тоот тушаалуудаар тус бүр 5 оюутанд кредит цагийн хөнгөлөлт үзүүлсний зэрэгцээ мөн сургалтын төлбөрөөс хөнгөлөгдөх урамшуулал олгосон.
- “Оюутанд урамшуулал олгох журам”-ыг УБЭИС -ийн ректорын 2016.03.15 өдрийн 21 тоот тушаалаар баталсан. Уг журамд ЭШХ, Олимпиад, Спорт, уралдаан тэмцээн, Соёл урлаг, наадам, сурлагаараа тэргүүлэгч оюутанд сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон кредитын хөнгөлөлт үзүүлнэ гэж тусгажээ. Сүүлийн 5 жилд НББ хөтөлбөрөөр тэтгэлэг авсан 19 оюутан байна

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд мэргэжлийн багш нар нь оюутны багаа идэвхтэй бэлдэж оруулдаг. Багш нар уралдаан тэмцээнд оюутны баг бэлтгэн оролцуулсан тохиолдолд багшийн ажлыг үнэлэх журамд заасны дагуу В цагийн гүйцэтгэлд 1.5 кредитын урамшуулал олгодог.
- Төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллахын тулд тэнхимийн суралцагчдад амжилттай яваа төгсөгчид ирж, яриа лекц хийдэг.
- Төгсөгч, ажил олгогчдын зүгээс тухайн сургуулийн НББ хөтөлбөрийн суралцагчдыг багш нар улсын чанартай уралдаан тэмцээнд бэлтгэн оролцуулдагт сэтгэл ханамж маш өндөр байна.
- “Спорт кредитийг хэрэгжүүлэх журам”-ыг захиргааны зөвлөлийн 2019.05.16 –ны хурлаар батлагдсан. Оюутны спорт кредитын биелэлтийн 1 кредитыг спорт аялал, секц дугуйлан, тэмцээн уралдаан, бие бялдрын сорил, нийтийн бие тамирын арга хэмжээнд хамрагдсан байдлаар цуглуулах боломжтой.

#### **Зөвлөмж:**

- Суралцагчдыг олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулах, нийгмийн идэвхийг өрнүүлэхэд сургууль, тэнхимийн зүгээс ажлын төлөвлөгөө гаргаж ажиллах.
- Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн дугуйлан клуб ажиллуулж, оюутны нийгмийн идэвх оролцоог дэмжих. Төлөвлөгөө, хуваарь, гүйцэтгэлийн тайлантай байх.
- Хууль зүйн зөвлөмжийн дагуу оюутныг цагийн болон үндсэн ажилд зуучлахад чиглэсэн бодлоготой байх.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрт сүүлийн 5 жилд 24 оюутан шилжин ирсэн .
- “Кредит дүйцүүлэн тооцох журам”-ыг УБЭИС-ийн Ректорын 2017 оын А/58 тушаалаар баталсан. Уг журмын гурав дахь заалтад суралцагчдын кредитийг тэнхим, салбар сургуулиар гаргуулан дүйцүүлэх шийдвэрийг хамтран гаргадаг.
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг сургалтын нэгдсэн журамд заасны дагуу зохицуулдаг /Ректорын 2019.09.20 ны №52 тоот тушаал/

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Шилжилт хөдөлгөөний судалгааг нэгтгэн гаргадаг бөгөөд шилжилт хөдөлгөөн суралцагчдын хувьд бага, нэгэнт элссэн оюутан тогтвортой суралцдаг.
- Суралцагч шилжин ирж байгаа гол хөшүүрэг нь сургалтын төлбөрийн уян хатан боломж сайн олгодог байна.

##### **Зөвлөмж:**

- Оюутны шилжилт хөдөлгөөний статистик мэдээг он, оноор нь харьцуулан гаргаж, дүн шинжилгээ хийх. Сургуулиас гарах, чөлөө авах, шилжин суралцагчдын шалтгааныг тодруулан судалдаг байх.
- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг журмандаа тодорхой болгож өгөх. Жишээлбэл: төгсөх курст шилжилт хөдөлгөөнийг зөвшөөрч хүлээн авах уу? Хэдэн кредитыг хүлээн зөвшөөрөх вэ? гэх мэт

#### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

##### **Илрэл нотолгоо:**

- УБЭИС-ийн ректорын 2016 оны 3 сарын 10-ны өдрийн тушаалаар батлагдсан “Диплом олгоход баримтлах журам” –г дагаж мөрддөг. Уг журамд төгсөлтийн баримт бичгийн бүрдүүлэлтэд юу юу байх ёстойг заасан байна.
- Төгсөлтийн шалгалтыг явуулах үйл ажиллагаа нь “Сургалтын нэгдсэн журам”-ын 17-д заасны дагуу явуулдаг.
- НББ хөтөлбөрөөр төгсөлтийн шалгалтыг цогц бодлого, асуултыг билет сугалуулах байдлаар зохион байгуулагддаг.



- Төгсөлтийн баримт бичгийн загвартай.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- 2021-2022 оны хичээлийн жилээс сургалтын төлөвлөгөөг шинэчлэн өөрчлөлт оруулснаар диплом бичих болзлыг хангасан оюутан диплом бичих боломжтой болсон.

### Зөвлөмж:

- Дипломын ажил бичих шаардлага, стандарт гаргаж мөрдүүлэх
- Төгсөх ангийн оюутны мэдээллийн санг бий болгож, цаашид төгсөгчийн мөшгих судалгааг авахад бэлтгэн, анхаарч ажиллах.
- Төгсөлтийн шалгалтыг зохион байгуулахад хөндлөнгийн үнэлгээ өгөх ажил олгогч, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулдаг байх.
- Төгсөх ангийн оюутанд чиглэсэн төгсөлтийн шалгалтын удирдамж, чиглүүлэн зөвлөх дэмжлэг үзүүлэх.

## 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- УБЭИС-ийн “Стратегийн төлөвлөгөө”-ний 5.2-д хүний нөөцийг хөгжүүлэх, профессор багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчлэх гэсэн заалт оруулсан байна. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу сонгон шалгаруулалт явуулж багшийг ажилд авдаг. /Зураг 4.1/
- УБЭИС-ийн ректорын 2018.06.20-ны өдрийн тушаалаар багш нарын туршлага, эрдмийн зэрэг дэвээс хамааруулан тэргүүлэх профессор, профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн ангиллыг тодорхойлж, ачааллыг тогтоосон. Ангилал бүрт ялгаатай албан тушаалын зэрэглэл, цалин хөлс, урамшууллыг тогтоосон байна. /Хүснэгт 6.2/

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Тэнхимийн саналыг үндэслэн багшийн сонгон шалгаруулалт явуулдаг.
- Үндсэн багш нараас 23 багш эрдмийн зэрэг цолтой. Эрдмийн зэрэг цолтой багш нарын хувийн жин 40.3% байна.

### **Анхаарах асуудал:**

- Багш нарын шагнал, урамшууллын бодлого, нийгмийн асуудлыг хэрхэн шийддэг нь тодорхой бус байна.
- НББ-ийн мэргэшүүлэх бүх хичээлийг 2 багш зааж байна.

### **Зөвлөмж:**

- Багш нарыг идэвхжүүлэх шагнал, урамшууллын болон нийгмийн асуудлыг бодлогоор дэмжих.
- Нягтлан бодох бүртгэлээр мэргэшүүлэх хичээл заах багшийн тоог нэмэгдүүлэх

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

УБЭИС-ийн зүгээс багшийн хөгжлийг дараах чиглэлүүдээр дэмжин ажилладаг байна. Үүнд:

- “Багшийн аттестатчиллын журам”
- Профессор, дэд профессор цол олгох журам”
- “Багшийн ёс зүйн журам”
- Багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.
- Багшийн хөгжлийн төв байгуулсан.

Багшийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь дараах зорилготой байна. Үүнд:

- Багшийг бэлтгэх мэргэжлийг дээшлүүлэх
- Багшийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засгийн болон хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Багшийн хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх сургалтын нэгж бүрт дэмжлэг үзүүлж чиглүүлэх
- Сургалтын нэгж хооронд багшийн хөгжлийн талаар туршлага мэдээллээ солилцох
- Багш бүр өөрийгөө хөгжүүлэхэд хариуцлагатай ханддаг байх гэх мэт агууламжийг багтаажээ.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжилт, багш нарт хүргэх, саналыг авах үйл ажиллагаа хангалтгүй байна.

**Зөвлөмж:**

- Дотоодын болон гадны улс орнуудын нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр бүхий сургуулийн багш нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох
- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлж “Багшийн хөгжил хөтөлбөр”-ийн хэрэгжилтэнд анхаарч ажиллах

**6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- УБЭИС-ийн стратегийн төлөвлөгөө 2018-2025, Стратегийн тэргүүлэх чиглэл-2 Эрдэм судлалын чадавхийг дээшлүүлж, инновацийн орчинг бүрдүүлэх талаар тусгасан байна.
- Сургуулийн хэмжээнд багш нарын судалгаа, шинжилгээний өргөн хүрээтэй ажил хийгддэг нь эрдмийн чуулган хурлыг жил бүр тогтмол зохион байгуулсан тайлан, “Эрдэм шинжилгээний бичиг” зэргээс харагдаж байна.
- Бусад их сургуулиудтай хамтарч ЭШ-ийн хурал хэлэлцүүлэг зохион байгуулдаг. /Хүснэгт 6.5/
- Эрдэм шинжилгээний хуралд зориулсан хөрөнгийн төсөв баталж зарцуулж ирсэн. /Хүснэгт 6.6/
- УБЭИС-ийн багш судлаачид дотоод гадаадын 10 шахам судалгааны ажилд хамтран оролцсон./Өөрийн үнэлгээний тайлан 101-102 дахь хуудас/

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалт судалгааны их сургууль болох стратегийн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа.
- Эрдмийн чуулган ЭШХ-г тогтмол зохион байгуулдаг.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн багш нарын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хэрхэн дэмжих нь тодорхой бус байна. НББ-ийн хөтөлбөртэй холбоотой судалгааны ажил харагдахгүй байна.
- НББ-ийн багш нарын судалгаан чиглэл тодорхой бус, оролцоо бага байна

**Зөвлөмж:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүнг хөтөлбөрөө сайжруулахад ашиглах.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш нарын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх зорилгоор 2015, 2018 онуудад багш нарыг 2 удаа аттестатчилсан. УБЭИС-ийн ректорын 2018.04.02-ны өдрийн 17 тоот тушаалаар багш нарыг аттестатчилах журмыг шинэчлэн баталсан. Шинэчилсэн журмаар цаашид багш нарыг 3 жил тутамд аттестатчилах юм байна.
- Шинэчилсэн журмаар профессор багш нарын сүүлийн 3 жилийн гүйцэтгэсэн ажлыг 700 хүртэл оноогоор үнэлэн дүгнэнэ. Багшийн үнэлгээ нь багшийн өөрийн үнэлгээний тайлан, тэнхмийн эрхлэгчээс өгсөн үнэлгээ, оюутны үнэлгээ зэргээс бүрддэг.
- Багшийн аттестатчилах үнэлгээгээр өндөр амжилт үзүүлсэн багш нарын цол зэргийг нэмэгдүүлнэ. Цол зэрэг ахисан багш нарын цалин урамшууллын хэмжээ дагаж нэмэгддэг байна. /Хүснэгт 6.9, Хүснэгт 6.10/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн үйл ажиллагааг төлөвлөх, ачаалал хуваарилах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ тодорхой бус, баримтжуулалт хангалтгүй байна. 2018 оноос хойш аттестатчилал хийгдээгүй.
- Багшийн ажлын төлөвлөгөө сургуулийн болон тэнхимийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдаж байгаа, төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, өөрийн үнэлгээний тайлан гаргахад анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Багшийн ажлын төлөвлөгөө нь тэнхим, сургуулийн төлөвлөгөө, зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн, хүрэх үр дүнтэй байх, мөн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх боломжтой өөрийн үнэлгээний тайлан бэлтгэдэг байх

#### **6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

### 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем гаргасан.
- УБЭИС –ийн Чанарын дотоод баталгаажуулалтын албыг ректорын 2017 оны 79 тоот тушаалаар байгуулсан. Ректорын 2021 оны 58 тоот тушаалаар Чанарын дотоод баталгаажуулалтын алба шинэчлэн байгуулагдсан.
- 2019 онд УБЭИС-ийн “Чанарын дотоод баталгаажуулалтын журам”-ыг баталсан.
- “Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын төлөвлөгөө”-г 2021-2022 оны хичээлийн жилд үндсэн дөрвөн үндсэн бүлгээр 10 дэд ажил хийхээр төлөвлөн гаргасан байна.
- Хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн талаар төгсөгчдөөс судалгаа авсан.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд чанарын үнэлгээг хийхдээ дараах чиглэлүүдээр судалгаа хийсэн. /Хүснэгт 7.2, Хүснэгт 7.3/ Үүнд:
  - Багшийн хичээлд сууж үнэлгээ өгсөн
  - Багшийн өдөр тутмын хийсэн ажилд үнэлгээ өгсөн
  - Оюутны сэтгэл ханамжийн судалгаа авсан
  - Багш ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан
  - Оюутанд олгосон мэдлэгийг үнэлсэн
  - Оюутны голч оноонд үнэлгээ өгсөн

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### Анхаарах асуудал:

- ЧДБ-ын албаны ажлын төлөвлөгөөг сургуулийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулах.
- ЧДБ-ын албаны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүр үнэлэж дүгнэх.
- ЧДБ-ын хүрээнд хийсэн оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн тайлан гаргах, цаашид сайжруулах арга замаа тодорхойлох.
- 2019 онд журам батлагдсанаас хойш хийсэн ажлын үр дүн байхгүй, тайлан байхгүй, үр дүнгийн хэрэгжилтийг үнэлдэггүй.

#### Зөвлөмж:

- ЧБА-ны ажлын төлөвлөгөөг сургуулийн стратеги төлөвлөгөө, чанарын баталгаажуулалтын журамд үндэслэн гаргах.

- ЧДБА-ны ажлын төлөвлөгөөнд оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, санал хүсэлтийг авч, цаашид хэрхэн сайжруулах талаар тусгах.
- Хөтөлбөр сайжруулалтад хөндлөнгийн үнэлгээг хийх аргачлалыг бий болгох.

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

### **Илрэл нотолгоо:**

- Төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгааг сүүлийн 3 жилд цаасан хэлбэрээр авсан.
- Ажил олгогчоос хөтөлбөрийн сайжруулалттай холбоотой санал хүсэлтийг авдаг.
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд дүн шинжилгээ хийсэн.
- Сангийн яамнаас авсан НББ мэргэжлээр суралцаж буй суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэх хөндлөнгийн үнэлгээнд улсын дундаж 39.3 байхад УБЭИС-ийн оюутнууд 39.4 байсан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын албанаас хичээлийн жилд 1 удаа багш нарын хичээлд сууж зөвлөн туслах, дүгнэлт өгөх байдлаар сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хяналт тавьдаг. Хуваарь жил бүр гардаг.
- Суралцагч, сургалтын албаны хөндлөнгийн үнэлгээнд үндэслэсэн судалгаа хийж дүгнэлт өгдөг.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хүрээнд хөтөлбөрийн оношлогоог 2019 онд хийлгэсэн. Үүнээс хойш цахим сургалт ковидтой холбоотой хийгдээгүй байгаа.
- Ажил олгогчийн зүгээс тус хөтөлбөрөөр төгсөгчдийн харилцаа, хандлага сайтай гэж цахим уулзалтаар санал хэлсэн .
- Төгсөгчид суралцаж байх хугацаандаа мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцож мэдлэг чадвар сайн эзэмшдэг, төгсөгчдийн чанар сайн байгааг онцолсон.

### **Анхаарах асуудал:**

- Ажил олгогчоос хөтөлбөрийн талаар авах сэтгэл ханамжийн судалгааг орхигдуулсан.

### **Зөвлөмж:**

- Төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг авч, үнэлэлт дүгнэлт өгдөг байх.
- Төгсөгчийн ажил эрхлэлтийн судалгааг авч, карьер өсөлтөд анализ хийдэг байх
- Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хөндлөнгийн үнэлгээ хийх арга зүйтэй болох
- Төгсөгчийн мөшгих болон карьер өсөлтийн судалгааг авч, сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх нэг үзүүлэлт болгох.

- Төгсөгч, ажил олгогчийн санал хүсэлтийг хөтөлбөр сайжруулалтанд тусгах.
- Багшийн хөгжлийн талаар багш нараас сэтгэл ханамжийн судалгааг авах

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- УБЭИС үндэсний хэмжээний хөндлөнгийн үнэлгээнд 3 удаа хамрагдсан.
- Үндэсний болон олон улсын уралдаант шалгаруулалтад хамрагдаж, дараах амжилтуудыг үзүүлж байгаа. Үүнд:
  - “Монголын их дээд сургуулиудын консорциумын жинхэнэ гишүүн сургууль”
  - Оюутанд ээлтэй сургууль
  - Шилдэг стандарт байгууллага
  - БМИҮЗ-ийн үндсэн гишүүн сургууль
  - АНУ-д төвтэй Олон улсын магадлан итгэмжлэлийн ACBSP байгууллагын гишүүн сургууль
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагатай 2017 онд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.
- Сургуулийн хэмжээнд дүрэм журмууд албан бичиг баримтуудыг сайн бүрдүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- 1995 оноос сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн, одоогоор 25 хөтөлбөр хэрэгждэг боловч Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж, итгэмжлэгдсэн хөтөлбөр хараахан байхгүй.
- Журмын хэрэгжилтэнд хөндлөнгийн үнэлгээг хийж, үр дүнгээ хэлэлцэж сайжруулахад анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг байх
- Гадаад, дотоодын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгааг хийх.
- Хөтөлбөрийн зорилгод ... Дотоодод төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодогч бэлтгэх тухай агуулга байгааг анхаарч олон улсын түвшинд хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэх боломжийг судлах

#### **7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн Хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3(6)	-	-	-
2	Сургалтын үйл ажиллагаа	2(4)	1(1)	-	2.2 Сургалтын арга зүй Удирдлагын мэдээллийн системийн шинэчлэл дуусаагүй, оюутан цахимаар мэдээлэл авах вэбгүй.
3	Хөтөлбөр хэрэг - жүүлэх орчин, технологийн нөхцөл	2(4)	1(1)	-	3.2 Сургалтын хэрэглэгдэхүүн НББ-ийн сургалтын цахим программгүй
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	3(6)	2(2)	-	4.1 хөтөлбөрийн удирлагын үйл ажиллагаа - Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад оролцогч талуудын оролцоо бага. - ULMS удирдлагын мэдээллийн системийн нэвтрүүлэлтийн ажил удаашралтай, оюутан мэдээлэл шууд хүлээн авах боломж хомс. <b>Санхүүжилт</b> -НББ хөтөлбөрийн багшийн хөгжилд, оюутны ЭША-д зориулсан хөрөнгө төлөвлөлт, гүйцэтгэлгүй -НББ-ээр хэрэгжүүлсэн төсөл, орлого байхгүй, - Элсэлт буурсан, хөтөлбөр алдагдалтай, нэг оюутанд ногдох өртөг тооцоогүй
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5(10)	-	-	-
6	Багшийн үйл ажиллагаа	4(8)	-	-	-
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3(6)	-	-	-
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Эдийн засаг бизнесийн сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг “Бизнесийн удирдлага” чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.



## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Эдийн засаг бизнесийн сургууль
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D041101
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	Хөтөлбөрийг боловсруулахдаа нягтлан бодогчдын ажлын байрны өсөлтөд судалгаа хийсэн боловч энэ мэргэжлээр жилд хэдэн сургууль хэдэн хүнийг бэлтгэн гаргаж байгааг судалсан эсэх нь тодорхойгүй байна. Иймд эрэлт нийлүүлэлтийн зөрүүг харгалзан өөрийн хөтөлбөрөөр авах элсэлтийн тоог тогтоох. Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн “НББ-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр”-ийн онцлог, гарцаагүй байх үндэслэлийг хөтөлбөрийн шинэчлэлд оруулж өгөх.
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	Сургалтын /танилцах/ болон үйлдвэрлэлийн /мэргэшүүлэх/ дадлага хийх орчноо бүрдүүлэхэд анхаарч, ажил олгогчидтой гэрээ байгуулж хамран ажиллах. Удирлагын мэдээллийн системийн шинэчлэлээ яаралтай дуусгаж, оюутны вэб-ийг ашиглалтад оруулах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	Суралцагсдын саналыг авч Номын сан, Уншлагын танхимын ажиллах цагийн хуваарийг нэмэгдүүлэх Номын санд нягтлан бодох бүртгэлийн сүүлийн үеийн ном сурах бичгүүдээр баяжуулалт хийх.
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Оролцогч талуудын санал, хүсэлтийг хүлээн авах, сонсох тогтолцоог төлөвшүүлэх зэрэг ажлуудаа нотолгоожуулах. НББ-ийн хөтөлбөрийн хамтын ажиллагаа, тэтгэлэг, хамтарсан хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг жигдрүүлэх, цахим хуудастай болгох, харилцаа, хамтын ажиллагаа, эргэх холбоог сайжруулах, төгсөлтийн дараах давтан сургалт зохион байгуулах. Хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, 1 оюутанд ногдох өртөг зардлыг тооцох. Маркетинг идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, элсэлтийн тоонд анхаарах, цар тахал гэх мэт нийгмийг хамарсан хямралын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	Сургуулийн албан ёсны цахим хуудсанд оюутантай холбоотой дүрэм журмыг нээлттэй болгох. Оюутны вэб-ийг яаралтай ажиллагаанд оруулах. Оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн мэргэжлийн хөтөлбөрийн үнэлгээг жилд тутам хийж, ахиц дэвшлээ гарган үнэлдэг байх. Жилийн тайланг тогтмол тайлагнаж, харьцуулалт хийх, дүн шинжилгээ тогтмол хийдэг байх. Оюутныг цагийн болон үндсэн ажилд зуучлахад чиглэсэн бодлоготой байх.

	<p>Оюутны нийгмийн идэвхийг өрнүүлэх ажлыг сургууль, тэнхимийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах.</p> <p>Дипломын ажил бичих шаардлага, стандарт гаргаж мөрдүүлэх.</p> <p>Төгсөх ангийн оюутны мэдээллийн санг бий болгож, цаашид төгсөгчийг мөшгих судалгааг бий болгох.</p>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<p>Багш нарыг идэвхжүүлэхэд шагнал, урамшууллын болон нийгмийн асуудлыг бодлогоор дэмжих.</p> <p>Дотоодын болон гадны улс орнуудын нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр бүхий сургуулийн багш нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох.</p> <p>Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлж, “Багшийн хөгжил хөтөлбөр” хэрэгжилтэд анхаарч ажиллах.</p> <p>Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн багш нараар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийлгэж, судалгааны үр дүнг хөтөлбөр сайжруулахад ашиглах.</p>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<p>ЧБА-ны ажлын төлөвлөгөөг сургуулийн стратеги төлөвлөгөө, чанарын баталгаажуулалтын журамд үндэслэн гаргах.</p> <p>Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх арга зүйтэй болох.</p> <p>Хөтөлбөрөө олон улсын хөндлөнгийн байгууллагаар магадлан итгэмжлүүлэх боломжийг судлах.</p>
<b>ШААРДЛАГА:</b> /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
Шалгуур 2.2 <b>Сургалтын арга зүй</b>	Удирдлагын мэдээллийн системийн шинэчлэлээ яаралтай дуусгаж, оюутны вэбийг ажиллагаатай болгох.
Шалгуур 3.1 <b>Сургалтын орчин</b>	Нягтлан бодох бүртгэлийн хэрэглээний программ авч, сургалтад ашиглах.
Шалгуур 4.1 <b>Хөтөлбөрийн удирлагын үйл ажиллагаа</b>	ULMS системийг яаралтай нэвтрүүлэх. Сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцогч талуудын оролцоог хангаж ажиллах.
Шалгуур 4.3 <b>Санхүүжилт</b>	НББ хөтөлбөр хэрэгжүүлэгч байгшийн хөгжилд, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд зориулсан төсвийг жил бүр батлан өгч, гүйцэтгэлийг хангаж ажиллах. Хөтөлбөр нь сургуульд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэх, өртөг зардлын тооцооллыг хийж, үнэлэн дүгнэж байх. Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс хөтөлбөр санхүүжих боломжийг тодорхойлон төлөвлөж, ажиллах.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг ..... Д.Далхжав

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Х.Нямбаяр

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Б.Оюунсүрэн

## IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

### I. Багш нарын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Ажилласан жил	Эрдмийн зэрэг цол	Тайлбар
1	О.Намжил	50 % профессор	Санхүү, Санхүүгийн менежмент	44	Доктор (Ph.D), профессор	
2	Н.Мөнхбаатар	Дэд профессор	Мэргэжлийн хичээлүүд	29	Дэд профессор	
3	Ц.Мягмарсүрэн	багш	Мэргэжлийн хичээлүүд	16	докторант	
4	Ч.Батхүү	Дэд профессор	Мэргэжлийн суурь хичээлүүд	25	магистр	
5	Д.Цэцэгсайхан	Ахлах багш	Мэргэжлийн суурь хичээлүүд	18	магистр	
6	Ц.Батзаяа	Гэрээт багш	Мэргэжлийн суурь ба мэргэжлийн хичээлүүд	17	докторант	
7	Н.Содномдорж	Зөвлөх профессор	Хүний хөгжил, Хөдөлмөрийн эдийн засаг	48	Ш/У-ны Доктор (Sc.D)	Гавъяат багш
8	О.Лхагварэнцэн	Гэрээт багш	Санхүү, бүртгэл, аудит	45	Доктор (Ph.D), профессор	Гавъяат эдийн засагч

### II. Оюутны нэрс

№	Овог нэр	Курс	Сонгосон байдал	Утасны дугаар
1	Шауран Айсымбат	IV	Орон нутаг	85950703
2	Мөнхбат Бумбаяр	IV	Орон нутаг	80421006
3	Отгон Барс-эрдэнэ	IV	Орон нутаг	88007882
4	Алтантуул Еэсил	IV		80779600
5	Шагдарсүрэн Намуунаа	IV		88682854
6	Болатхан Нургулан	IV	Орон нутаг	85585151
7	Батбилэг Нямцэцэг	IV		86203600
8	Буяндэлгэр Нямдорж	IV	Хөнгөлөлттэй	88714005
9	Серболат Сайранбек	IV	Орон нутаг	99637745
10	Гансүх Урандарь	IV		99846934

11	Ганболд Номин-эрдэнэ	II		80374445
12	Батбаатар Нямбар	II		88149989
13	Сайнжаргал Өөдөөзаяа	II		99575562
14	Бөганбай Сынап	II	Орон нутаг	88141862
15	Оюусүх Тулга-Эрдэнэ	II		88829774
16	Батсуурь Пүрэвдулам	II		95505396
17	Мөнхжаргал Дөлгөөн	I		88137827
18	Бишгүй Нямбаяр	I		96802380
19	Аззаяа Анима	I	Дотуур байр	99598668
20	Алтанхуяг Номин-Эрдэнэ	I		85277078
21	Дамдинсүрэн Сугаржаргал	I		89408333
22	Батмөнх Нямгэрэл	I	Төлбөр хямд	80817779


### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэр	Албан тушаал	Байгууллага	Утасны дугаар
1	Сандуйжав Түмэнбаяр	Салбарын эрхлэгч	Remax үл хөдлөх хөрөнгийн зуучлах компани	99162837
2	Гэндэн Тэгшбүрэн	Захирал	Хүний нөөцийн судалгааны хүрээлэн	99114348
3	Ганбат Цогтгэрэл	Менежер	Амар даатгал	99073686
4	Дашдоног	Зөвлөх	Нийгмийн даатгалын ерөнхий газар	99141855
5	Цэрэн-Ойдов Батмандах	Албаны дарга	БЗД-ийн ТГ-ын дотоод аудит	99009099
6	Төмөрбаатар Цэцэгмаа	Хөтөлбөрийн мэргэжилтэн	ММНБИ	99904554
7	Баяраа Алтанцэцэг	Ерөнхий нягтлан бодогч	Таванбогд групп Жуулчин компани	99097301

#### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог Нэр	Төгссөн он	Албан тушаал	Байгууллага
1	Энхтуул	2011	Ахлах нягтлан	Төмөр зам
2	Дэлгэрцэцэг Номиндарь	2012	Багш	Мандах Их Сургууль
3	Хишигбодрол Хишигзаяа	2016	Нягтлан	"Mild cosmetic" ХХК
4	Галтбаатар Одонцэцэг	2016	Нягтлан	"Баатархайрхан" ХХК
5	Эрдэнэчулуун Энхжаргал	2016	Салбар хариуцсан дарга	МҮОНТ Сүхбаатар аймаг
6	Баярмагнай Гэрэлтсүвд	2017	Ахлах ажилтан	"Амар" даатгал
7	Баясгалан Эрдэнэбаяр	2017	Зээлийн эдийн засагч	Хаан банк
8	Өлзий Тамир	2017	Ахлах нягтлан	"ХН-ОД" ХХК
9	Чойбаатар Эрдэнэцацрал	2017	Нягтлан	"Хусхан" ХХК
10	Төмөрбаатар Тайванбаатар	2017	Ахлах нягтлан	Таванбогд групп
11	Оюунчимэг Хишигсүрэн	2019	Харилцагчийн мэргэжилтэн	Хаан банк
12	Шинэхүү Бямбасүрэн	2019	Теллер	Хаан банк
13	Энхтүвшин Базаррагчаа	2019	Нягтлан	"БСУ" ХХК
14	Гүрцоо Хулан	2019	Нягтлан	"И БИ ЭЙ ТОВЕР" ХХК
15	Баярхүү Энхцэцэг	2019	Нягтлан	HITECH United
16	Цэндсүрэн Гомбосүрэн	2020	Нягтлан	Тэргүүн магни
17	Цогтбаяр Амарсайхан	2020	Нярав	Булган аймаг ОБГ
18	Хорлоо Болор-Эрдэнэ	2020	Нягтлан	"Мост машинт" ХХК
19	Оюунчимэг Ундармаа	2018	Нягтлан	Dark Sky Mongolia
20	Болор Ундраа	2020	Нягтлан	Налайх ЗДТГ
21	НасантогтохИчинхорлоо	2017	Магистрант	Чичихар Их Сургууль
22	Энхбаяр Батзаяа	2017	Нягтлан	"Даваа заан" ХХК

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
**/албан бичгийг оруулах/**

 **УЛААНБААТАР ЭРДЭМ  
ИХ СУРГУУЛЬ** Г БМИҮЗ –д Г



Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо  
Шуудангийн хайрцаг - 46/33.  
Утас: 328198, 326280, 311776, 318490,  
Факс: (976-11) 328198.  
Web: [uberdem.edu.mn](http://uberdem.edu.mn)  
E-mail: [info@uberdem.edu.mn](mailto:info@uberdem.edu.mn)

2022.05.16 № 205

Танай \_\_\_\_\_ ны /ний/ № \_\_\_\_\_ -т

Г Шинжээчдийн нэгдсэн зөвлөмж, шаардлагад тайлбар хүргүүлэх тухай Г

Тус сургуулийн НББ-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шинжээчдийн багаас ирүүлсэн нэгдсэн зөвлөмж, шаардлагыг бүрэн хүлээн зөвшөөрч байна. Эдгээр нэгдсэн зөвлөмж, шаардлагыг тус хөтөлбөрийн “Ахиц дэвшлийн дунд хугацааны төлөвлөгөө” –нд тусган хэрэгжүүлэх болно. Энэ тухай тайлбарыг хавсралтаар хүргүүлэв.

  АКАДЕМИЧ Т. ДОРЖ

2022 оны 05 сарын 16 өдрийн  
 2022 тоот албан бичгийн 1-р хавсралт



**НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГЫН ТАЙЛБАР**

Сургуулийн нэр	Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн Эдийн засаг бизнесийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Нягтлан бодох бүртгэл
Хөтөлбөрийн индекс	D041101

ЗӨВЛӨМЖ	ТАЙЛБАР
<b>ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ</b>	
а/ Хөтөлбөрийг боловсруулахдаа нягтлан бодогчдын ажлын байрны өсөлтөд судалгаа хийсэн боловч энэ мэргэжлээр жилд хэдэн сургууль хэдэн хүнийг бэлтгэн гаргаж байгааг судалсан эсэх нь тодорхойгүй байна. Иймд эрэлт нийлүүлэлтийн зөрүүг харгалзан өөрийн хөтөлбөрөөр авах элсэлтийн тоог тогтоох.	НББ-ийн сургалтын хөтөлбөрийн ахиц дэвшлийн дунд хугацааны /2022-2027 он/ төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд уг зөвлөмжийг тусган хэрэгжүүлэх болно.
б/ Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн “НББ-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр”-ийн онцлог, гарцаагүй байх үндэслэлийг хөтөлбөрийн шинэчлэлд оруулж өгөх.	“НББ-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр”-ийн онцлог, гарцаагүй байх үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, хөтөлбөрийн шинэчлэлд оруулж өгнө.
<b>ШАЛГУУР 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	
а/ Сургалтын /танилцах/ болон үйлдвэрлэлийн /мэргэшүүлэх/ дадлага хийх орчноо бүрдүүлэхэд анхаарч, ажил олгогчидтой гэрээ байгуулж хамтран ажиллах.	Гэрээтэй байгууллагууд байгаа бөгөөд цаашид гэрээг шинэчлэн сунгаж ажиллана.
б/ Удирлагын мэдээллийн системийн шинэчлэлээ яаралтай дуусгаж, оюутны вэб-ийг ашиглалтад оруулах	Сургуулийн серверийн хүчин чадлыг өргөтгөх үндсэн дээр энэ зөвлөмжийг 2022-2023 оны хичээлийн жил эхлэхэд хэрэгжүүлсэн байна.
<b>ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨӨЦ</b>	
а/ Суралцагсдын саналыг авч Номын сан, Уншлагын танхимын ажиллах цагийн хуваарийг нэмэгдүүлэх.	2 номын санчийн нэгний төрсний амралт нь дуусч, намраас ажилд орох учир энэ асуудал шийдэгдэнэ.
б/ Номын санд нягтлан бодох бүртгэлийн сүүлийн үеийн ном сурах бичгүүдээр баяжуулалт хийх.	Нягтлан бодох бүртгэлийн сүүлийн үеийн ном сурах бичгүүдийн судалгаа хийх үндсэн дээр, баяжуулалт хийнэ.
<b>ШАЛГУУР 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</b>	
а/ Оролцогч талуудын санал, хүсэлтийг хүлээн авах, сонсох тогтолцоог төлөвшүүлэх зэрэг ажлуудаа нотолгоожуулах.	Цаашид тухай бүр протокол хөтлөх, тайланг нэгтгэн баталгаажуулах, үр дүнг ашиглах зэргээр нотолгооны баримт бүрдүүлж явна.
б/ НББ-ийн хөтөлбөрийн хамтын ажиллагаа, тэтгэлэг, хамтарсан хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх.	Тэтгэлэг, хамтарсан хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх зэрэгт анхаарч ажиллана.
в/ Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг жигдрүүлэх, цахим хуудастай болгох, харилцаа, хамтын ажиллагаа, эргэх холбоог сайжруулах, төгсөлтийн дараах давтан сургалт зохион байгуулах.	-Төгсөгчдийн холбоог цахим хуудастай болгоё. -Төгсөгчдийн холбооны гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, тайлантай болно. - Давтан сургалт зохион байгуулах боломжийг цаашид судалъя.

в/ Хөтөлбөрөө олон улсын хөндлөнгийн байгууллагаар магадлан итгэмжлүүлэх боломжийг судлах.	Энэ боломжийг өмнө нь судалж, олон улсын байгууллагад гишүүнээр хүртэл элсэж байсан. Цаашид үргэлжлүүлэх боломж бий.
<b>ШААРДЛАГА</b>	
Шалгуур 2.2 Сургалтын арга зүй - Удирдлагын мэдээллийн системийн шинэчлэлээ яаралтай дуусгаж, оюутны вэбийг ажиллагаатай болгох.	2022 онд багтааж гүйцэтгэнэ.
Шалгуур 3.1 Сургалтын орчин - Нягтлан бодох бүртгэлийн хэрэглээний программ авч, сургалтад ашиглах.	Ирэх хичээлийн хичээлийн жилд хэрэгжүүлэх боломжтой.
Шалгуур 4.1 Хөтөлбөрийн удирлагын үйл ажиллагаа - ULMS системийг яаралтай нэвтрүүлэх. - Сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцогч талуудын оролцоог хангаж ажиллах.	Сургуулийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай. ULMS системийг нэвтрүүлэх ажил энэ хичээлийн жилд дуусах хүлээлттэй байгаа. Цаашид сургалтын хөтөлбөрөө шинэчлэн сайжруулахдаа энэ зөвлөмжийг анхаарах болно.
Шалгуур 4.3 Санхүүжилт - НББ хөтөлбөр хэрэгжүүлэгч багшийн хөгжилд, оюутны эрдэм шинжилгээ судалгааны ажилд зориулсан төсвийг жил бүр батлан өгч, гүйцэтгэлийг хангаж ажиллах. - Хөтөлбөр нь сургуульд эдийн засгийн хувьд үр ашигтай эсэх, өртөг зардлын тооцооллыг хийж, үнэлэн дүгнэж байх. - Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс хөтөлбөр санхүүжих боломжийг тодорхойлон төлөвлөж, ажиллах.	<ul style="list-style-type: none"> <li>- Одоогоор ийм практик байхгүй байгаа. УБЭИС-ийн удирдлага энэ асуудалд анхаарлаа хандуулж байгаа.</li> <li>- Өдрийн хөтөлбөр алдагдалтай байх нөхцөл үүслээ ч гэсэн орой, эчнээгээс алдагдлыг нөхөх бүрэн боломж одоогоор байгаа.</li> <li>- Олон эх үүсвэрээс хөтөлбөр санхүүжүүлэх боломж нь багш нарын урамшуулал, идэвхээс ихээхэн хамааралтай. Иймд юуны түрүүнд багш нарын урамшуулал, нийгмийн асуудал, идэвхи санаачилгыг өрнүүлэхэд сургуулийн бүх шатны удирдлага анхаарч ажиллах шаардлагатай байгаа.</li> </ul>



г/Хөтөлбөрийн санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, 1 оюутанд ногдох өртөг зардлыг тооцох.	1 оюутанд ногдох өртөг зардлыг тооцох, сургуулийн төсвийн шинэчлэлт хийх шаардлага байгаа.
д/Маркетинг идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах, элсэлтийн тоонд анхаарах, цар тахал гэх мэт нийгмийг хамарсан хямралын эсрэг хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Маркетингийн суваг, идэвхижүүлэлийг сайжруулах замаар элсэлтийн тоог нэмэгдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байгаа.
<b>ШАЛГУУР 5. СУРАЛЦАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	
а/ Сургуулийн албан ёсны цахим хуудсанд оюутантай холбоотой дүрэм, журмыг нээлттэй болгох.	Сургуулийн серверийн хүчин чадлыг өргөтгөх үндсэн дээр хичээлийн жил бүр Оюутны гарын авлагыг шинэчилж, Оюутны ВЭБ-д байршуулах бүрэн боломжтой.
б/ Оюутны вэб-ийг яаралтай ажиллагаанд оруулах	Сургуулийн серверийн хүчин чадлыг өргөтгөх үндсэн дээр Оюутны ВЭБ-ийг 2022 онд багтааж ажиллагаанд оруулна.
в/Оролцогч, сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн мэргэжлийн хөтөлбөрийн үнэлгээг жилд тутам хийж, ахиц дэвшлээ гарган үнэлдэг байх. Жилийн тайланг тогтмол тайлагнаж, харьцуулалт хийх, дүн шинжилгээ тогтмол хийдэг байх.	Ахиц дэвшлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хичээлийн жил бүр гаргаж, тэхим, сургуулиар хэлэлцэн дүн шинжилгээ хийдэг болно.
г/Оюутныг цагийн болон үндсэн ажилд зуучлахад чиглэсэн бодлоготой байх.	Энэ ажлыг Оюутны холбоотой хамтран хэрэгжүүлж ирсэн туршлага байгаа.
д/Оюутны нийгмийн идэвхийг өрнүүлэх ажлыг сургууль, тэнхимийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах.	Энэ зөвлөмжийг ирэх хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж эхэлье.
е/Дипломын ажил бичих шаардлага, стандарт гаргаж мөрдүүлэх.	
ё/Төгсөх ангийн оюутны мэдээллийн санг бий болгож, цаашид төгсөгчийг мөшгих судалгааг бий болгох.	Төгсөгчдийн холбооны гүйцэтгэдэг нэг ажил болгох замаар энэ зөвлөмжийн хэрэгжүүлэх бүрэн боломж байна.
<b>ШАЛГУУР 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>	
а/Багш нарыг идэвхжүүлэхэд шагнал, урамшууллын болон нийгмийн асуудлыг бодлогоор дэмжих.	УБЭИС-ийн ТҮЗ, Эрдэмийн зөвлөл, Захиргааны зөвлөл зэрэг удирдах байгууллагууд энэ зөвлөмжийг анхааралдаа авч ажиллах байх.
б/Дотоодын болон гадны улс орнуудын нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр бүхий сургуулийн багш нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох.	Цаашид хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж энэ зөвлөмжид анхаарал хандуулан ажиллах болно.
в/Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлж, “Багшийн хөгжил хөтөлбөр” хэрэгжилтэд анхаарч ажиллах.	Хариуцсан мэргэжилтэнтэй болсон. Энэ асуудал цаашид улам сайжрах байх.
г/Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн багш нараар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийлгэж, судалгааны үр дүнг хөтөлбөр сайжруулахад ашиглах.	Цаашид хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж энэ зөвлөмжид анхаарал хандуулан ажиллах болно.
<b>ШАЛГУУР 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ</b>	
а/ ЧБА-ны ажлын төлөвлөгөөг сургуулийн стратеги төлөвлөгөө, чанарын баталгаажуулалтын журамд үндэслэн гаргах.	ЧБА энэ зөвлөмжийг цаашид хэрэгжүүлэн ажиллана.
б/ Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх арга зүйтэй болох.	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх арга зүй, бусад их сургуулийн туршлагыг судалж, өөрийн арга зүйтэй болоход анхааръя.

## ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2022-06-07  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮІІ. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**